



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Худалдаа хөгжлийн банк” ХХК-иас гадаадын
хөрөнгийн бирж дээр гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй 5 жилийн хугацаатай, 1,500,000,000 /нэг тэрбум таван зуун сая/ юанын үнийн дүн бүхий 1,500 ширхэг өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д зааснаар Хороо нийтэд санал болгон гаргах дээрх үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа биш бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан аливаа эрсдэлийг Монгол улсын төр хариуцахгүй болохыг тэмдэглэсүгэй.

3. Гадаад улсын зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Худалдаа хөгжлийн банк” ХХК /Б.Мэдрээ/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу үнэт цаасыг гадаадын хөрөнгийн зах зээл дээр байршуулсан тухай болон арилжаалагдаж буй үйл явцын талаар хагас жил тутамд Хороонд тайлагнаж байх;

2/ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнгийн болон нийтэд санал болгон өмнө нь гаргаж байсан үнэт цаасны төлбөрийн талаарх бодитой мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангаж, тэдгээрийн хууль ёсны эрхийг хангаж ажиллах.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000910